



ЗАВХАН АЙМАГ
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА УЛСЫН
АХЛАХ БАЙЦААГЧИЙН АКТ

2024 оны 12 сарын 09 өдөр

Дугаар 87

Улиастай

НӨХӨН ТӨЛБӨР ТОГТООЖ ТӨЛҮҮЛЭХ ТУХАЙ

Албаны 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу даргын 2024 оны 10 сарын 01-ний 32 дугаар удирдамжаар Завхан аймгийн **Ус цаг уур орчны шинжилгээний төв**-ийн 2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж гүйцэтгэв.

Шалгалтаар албан хаагчид олгох хөдөлмөрийн хөлсийг илүү тооцоолон олгосон, эрх бүхий албан тушаалтны шийдвэргүй, сахилгын шийтгэлтэй байх хугацаа нь дуусгавар болоогүй албан хаагчдад, мөн ажиллаагүй улиралд ажлын үр дүнгээр тооцох мөнгөн урамшууллыг тус тус олгосон **3 606 093** төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.1.4 “төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.8 “хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцно” Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3-р хавсралтын 2.1 “хуульд өөрөөр заагаагүй бол улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил, үүргээ хангалттай гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй албан хаагчид олгоно”, 2.3 “энэхүү журмын 2.1-д заасан нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг энэ журмын 1.2-т заасан тухайн төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан гаргана”, 2.7 “хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Монгол улсын “Төрийн хяналт шалгалтын тухай” хуулийн 10 дугаар зүйлийн 10.12.2 “Аж ахуй нэгж, байгууллага, иргэний хууль бусаар олсон орлого, эд хөрөнгийг акт үйлдэж улсын орлого болгох, түүнчлэн бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх” заалтыг үндэслэн **ТОГТООХ** нь:

Нэг. Нөхөн төлбөрийн **3 606 093** төгрөгийг хариуцагч хүмүүсээр төлүүлж төсвийг хохиролгүй болгох

Хоёр. Дээрх зөрчилтэй холбоотой **3 606 093** төгрөгийн нөхөн төлбөрийг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор Орон нутгийн төсвийн орлогын төрийн сан дахь 100090000982 тоот дансанд төвлөрүүлж тайлан ирүүлэхийг дарга Э.Мөнгөнцэцэг нягтлан бодогч Б.Ням-Осор нарт хариуцуулав.

Гурав. Актанд “Төрийн хяналт шалгалтын тухай” хуулийн 14-р зүйлийн 14.1

“Шалгуулсан байгууллага, аж ахуй нэгжийн эрх баригч, албан тушаалтан хяналт шалгалтын явцад хууль тогтоомж зөрчигдсөн, гаргасан шийдвэр үндэслэлгүй гэж үзвэл гомдлоо хяналт шалгалт хийсэн байгууллагын эрх баригчид гаргана”-ыг заалтын дагуу гомдол гаргах эрхтэй.

АКТ ТОГТООСОН:

ДОТООД АУДИТОР- САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ Ц.МЯДАГМАА

ДАРГА

НЯГТЛАН БОДОГЧ

ЗӨВШӨӨРСӨН:

Э.МӨНГӨНЦЭЦЭГ

Б.НЯМ-ОСОР

9039066 СТА3949 0922070024